



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Аудитын код: УВА-2022/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Увс аймгийн Улаангом сум
2022 он

Цахим хуудас: uvs@audit.gov.mn

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317
Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799
Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит"
ХХК аудитор: С.Цэрэнминжин
Утас: 99458717
Цахим хаяг: enhee_ja@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХЯРГАС СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Я.БАТМӨНХ
ТАНАА

додд. о.д. 25 № ЧБА-2022/75/НА-ОТА-ТМС
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гаж үзлэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Я.БАТМӨНХ Я.БАТСУУРЬ



0200200501

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	1,960,788.00	00.00
335	Бусад авлага	1,960,788.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,960,788.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,712,500.00	00.00
354	Хангамжийн материал	8,427,500.00	00.00
35410	Бичиг хэргийн материал	1,380,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	1,266,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	5,781,500.00	00.00
35600	Мал амьтад	3,285,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	41,294,272.94	58,970,888.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	41,294,272.94	58,970,888.04
392	Биет хөрөнгө	34,336,272.94	52,012,888.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	34,420,506.00	34,420,506.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,125,359.58	-14,571,539.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	30,536,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-11,451,162.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	149,235,700.00	140,172,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-137,186,295.42	-127,566,472.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,643,449.70	2,331,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,651,727.76	-1,858,777.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	632,000.00	632,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-632,000.00	-632,000.00
393	Биет бус хөрөнгө	6,958,000.00	6,958,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,958,000.00	6,958,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	54,967,560.94	58,970,888.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	54,967,560.94	58,970,888.04
51	Засгийн газрын хувь оролцоо	54,967,560.94	58,970,888.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	272,712,495.00	272,712,495.00
51101	Өмч: - төрийн	272,712,495.00	272,712,495.00
512	Хуримтлагдсан үр дүн	-252,849,204.35	-248,800,465.01
51210	Өмнөх үеийн үр дүн	-252,849,204.35	-252,803,792.11
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,003,327.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,104,270.29	35,058,858.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	54,967,560.94	58,970,888.04

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл / төгрөгөөр /
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	84,443,200.00	109,131,534.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,500,000.00	30,536,434.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,500,000.00	30,536,434.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,500,000.00	30,536,434.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,500,000.00	30,536,434.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,943,200.00	78,595,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,943,200.00	77,780,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,943,200.00	77,780,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	67,359,884.84	104,704,707.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,359,884.84	104,704,707.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,319,857.84	92,052,313.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,399,069.00	46,372,401.00
210101	Үндсэн цалин	37,240,659.00	37,681,261.00
210104	Урамшуулал	8,158,410.00	8,691,140.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,692,804.00	5,980,455.55
210201	Тэтгэврийн даатгал	3,881,607.00	4,169,625.89
210202	Тэтгэмжийн даатгал	449,374.00	463,803.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	341,990.00	360,998.70
210204	Ажилгүйдлийн даатгал	111,946.00	89,644.40
210205	Эрүүл мэндийн даатгал	907,887.00	896,383.30
2104	Хангамж, бараа материалын зардал	4,235,800.00	18,782,538.00
210401	Бичиг хэрэг	1,180,000.00	1,865,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,953,300.00	6,187,138.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	102,500.00	7,445,400.00
210408	Бараа материал актальсны зардал	00.00	3,285,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	80,000.00
2107	Томилолт, зочны зардал	702,157.00	576,000.00
210702	Дотоод албан томилолт	702,157.00	576,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	291,250.00	144,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	144,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,698,777.84	20,116,919.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,344,000.00	4,149,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	354,777.84	15,967,919.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,040,027.00	12,652,393.45
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	89,027.00	6,172,593.45
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	89,027.00	6,172,593.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,951,000.00	6,479,800.00

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,951,000.00	166,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	17,083,315.16	4,426,826.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	423,499.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	423,499.62
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-423,499.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	17,083,315.16	4,003,327.10

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	70,943,200.00	78,595,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,943,200.00	78,595,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,943,200.00	77,780,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,943,200.00	77,780,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	70,943,200.00	78,595,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,943,200.00	78,595,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,154,173.00	65,942,706.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,509,523.00	45,098,018.01
210101	Үндсэн цалин	37,722,423.00	36,467,018.01
210104	Урамшуулал	8,787,100.00	8,631,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,332,600.00	5,504,588.54
210201	Тэтгэврийн даатгал	4,456,400.00	3,820,723.01
210202	Тэтгэмжийн даатгал	469,100.00	428,130.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	375,200.00	334,478.88
210204	Ажилгүйдлийн даатгал	93,800.00	89,222.67
210205	Эрүүл мэндийн даатгал	938,100.00	832,033.10
2104	Хангамж, бараа материалын зардал	3,910,800.00	5,018,350.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	785,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,690,800.00	4,135,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	120,000.00	97,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,440,000.00	1,912,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	1,832,600.00
210604	Урсгал засвар	240,000.00	80,000.00
2107	Томилолт, зочны зардал	670,000.00	576,000.00
210702	Дотоод албан томилолт	670,000.00	576,000.00

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	291,250.00	144,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	7,689,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,795,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	3,893,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,789,027.00	12,652,393.45
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	89,027.00	6,172,593.45
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,700,000.00	6,479,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,700,000.00	166,600.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,712,495.00	35,104,270.29	-252,849,204.35	54,967,560.94
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	272,712,495.00	35,104,270.29	-252,849,204.35	54,967,560.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	45,412.24	45,412.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,712,495.00	35,104,270.29	-252,803,792.11	55,012,973.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-45,412.24	00.00	-45,412.24
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,003,327.10	4,003,327.10

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,712,495.00	35,058,858.05	-248,800,465.01	58,970,888.04
-----	---------------------------------------	----------------	---------------	-----------------	---------------

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,780,100.00	71,638,006.55	6,142,093.45	92%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,780,100.00	71,638,006.55	6,142,093.45	92%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,300,300.00	65,158,206.55	6,142,093.45	91%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,909,800.00	45,098,018.01	1,811,781.99	96%
210101	Үндсэн цалин	36,867,400.00	36,467,018.01	400,381.99	99%
210104	Урамшуулал	10,042,400.00	8,631,000.00	1,411,400.00	86%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	6,332,600.00	5,504,588.54	828,011.46	87%
210201	Тэтгэврийн даатгал	4,456,400.00	3,820,723.01	635,676.99	86%
210202	Тэтгэмжийн даатгал	469,100.00	428,130.88	40,969.12	91%
210203	ҮОМШӨ-ний даатгал	375,200.00	334,478.88	40,721.12	89%
210204	Ажилгүйдлийн даатгал	93,800.00	89,222.67	4,577.33	95%
210205	Эрүүл мэндийн даатгал	938,100.00	832,033.10	106,066.90	89%
2104	Хангамж, бараа материалын зардал	6,092,500.00	5,018,350.00	1,074,150.00	82%
210401	Бичиг хэрэг	785,000.00	785,000.00	0.00	100%
210402	Тээвэр, шатахуун	5,209,600.00	4,135,450.00	1,074,150.00	79%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	97,900.00	97,900.00	0.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,912,600.00	1,912,600.00	0.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,832,600.00	1,832,600.00	0.00	100%
210604	Урсгал засвар	80,000.00	80,000.00	0.00	100%
2107	Томиллолт, зочны зардал	594,400.00	576,000.00	18,400.00	97%
210702	Дотоод албан томилолт	594,400.00	576,000.00	18,400.00	97%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	489,400.00	144,000.00	345,400.00	29%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,400.00	00.00	193,400.00	0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	144,000.00	72,000.00	67%
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	00.00	80,000.00	0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8969000.00	6904650.00	2,064,350.00	77%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,936,000.00	3,795,650.00	140,350.00	96%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,033,000.00	3,109,000.00	1,924,000.00	62%

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6479800.00	6479800.00	0.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,479,800.00	6,479,800.00	0.00	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	6,313,200.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	166,600.00	166,600.00	0.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,780,100.00	77,780,100.00	0.00	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,780,100.00	77,780,100.00	0.00	100%
132001	Орон нутгийн төсвөөс	77,780,100.00	77,780,100.00	0.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	06.00	06.00	0.00	100%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	01.00	01.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00	100%

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815000.00	784,500.00	30,500.00	96%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815000.00	784,500.00	30,500.00	96%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	815000.00	784,500.00	30,500.00	96%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	815000.00	784500.00	30,500.00	96%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	815000.00	784,500.00	30,500.00	96%
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	815000.00	815000.00	0.00	100%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815000.00	815,000.00	0.00	100%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815000.00	815,000.00	0.00	100%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 67,359.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,347.2 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 95,955.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,919.1 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцох хувийг 80 хувиар тооцож 1,535.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,003.3 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,960,788.00	00.00	-1,960,788.00
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	11,712,500.00	00.00	-11,712,500.00
Үндсэн хөрөнгө	41,294,272.94	58,970,888.04	17,676,615.10
Нийт хөрөнгө	54,967,560.94	58,970,888.04	4,003,327.10
Өр төлбөр	00.00	00.00	00.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	54,967,560.94	58,970,888.04	4,003,327.10
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	54,967,560.94	58,970,888.04	4,003,327.10

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Өмнөх онд үүссэн авлагыг бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,712.5 мянган төгрөгөөр буурсан нь үлдэгдэл бараа материалыг зарцуулж, актлагдсан бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 58,970.8 мянган төгрөг болж 17,676.6 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хөрөнгөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 55,196.5 мянган төгрөг болж 4,003.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөн шалтгаалжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь бараа материал, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 24,688.3 мянган төгрөгөөр буюу 29.2 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 28,595.6 мянган төгрөгөөр буюу 42.4 хувиар өссөн байна. Энэ нь цалин, бараа материалын, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 91,987.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 91,987.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14,207.4 мянган төгрөгөөр бууруулж 77,780.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь эд хогшил худалдан авах зардал, болон хангамжийн бараа материалын төлөвлөсөн зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 77,780.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 77,780.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 77,780.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 71,607.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 71,607.6 мянган төгрөг буюу 92.1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 815.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр өгсөн байна.

Үүнээс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 784.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 117, хугацаа болоогүй 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулахаас заасан ч бензин шатахуунд зарцуулсан 1,872.1 мянган төгрөгийн ажлын тайланг хавсаргаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг авч ажиллаж 6,172.5 мянган төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэн байна.

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хяргас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	26,784.7	2	24,912.6					1	1,872.1
---	---	----------	---	----------	--	--	--	--	---	---------

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/



БЭЛТГЭСЭН:

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР

/С.ЦЭРЭНМИНЖИН/

2022 оны 2-р сарын 21-ний өдөр

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26,784.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 24,912.6 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 1,872.1 мянган төгрөгийг арилгуулахаар зөвлөмж өгсөн.

Үүнд:

4.1 Залруулга

1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 12,389.1 мянган төгрөгөөр илүү, үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг 12,523.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байсныг залруулга хийлгэсэн.

4.2 Зөвлөмж

2. Зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 1,872.1 мянган төгрөгийн бензин шатахууны зарцуулалтын тайлан хавсаргаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

1. Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дахь хэсэгт тусгагдсан зардлыг санхүүжүүлэх.
2. Гэмт хэргээс сэргийлэх зардлаас зарцуулсан хөрөнгийн ажлын тайлан, шатахууны зарцуулалтыг тайланг гаргаж замын хуудсанд хавсаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн